



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/301

Номгон


“Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл  
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл  
олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэнд, сувиллын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх “Амар амгалан Шаргалжуут” ХХК-ний “Амар Амгалан” сувилалд тусгай зөвшөөрөл шинээр олгосугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-т, Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтийг мөрдүүлэхэд удирдлага арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Энхжаргал)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН